



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 1179

Шивээговь сум

Газар өмчлөх эрхийг баталгаажуулах  
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбилцлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжүүлсэнтэй холбогдуулан иргэн Тайж овогт Даваагийн Мөнхчимэгийн өмчилж авсан 2 дугаар баг, Нэрт 2-01 тоот 750м2 газар нь мэргэжлийн байгууллагаар суурин газрын кадастрын зургийг хийхэд талбайн хэмжээ нь өөрчлөгдсөн тул Даваагийн Мөнхчимэгт Нэрт 2-1 тоот 898 м2, 1257200 (нэг сая хоёр зуун тавин долоон мянга хоёр зуу) төгрөг бүхий газрыг өмчлүүлсүгэй.

2. Газрын хэмжээ нь өөрчлөлт орж буй газраа Улсын бүртгэлд бүртгүүлэхийг иргэн /Даваагийн Мөнхчимэг/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 50 дугаар захирамжийн 55 дахь хүснэгтийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ

